**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

РҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
АРИЙН БИЧГИЙН ДАРГА

АРЖАРГАЛ

**НИЙЛҮҮЛЭГЧ**

“ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.НАНСАЛМАА

## ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 520

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас алдваргүйжүүлэлт” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг арилцан тохиролцож 2020 оны 12. дугаар сарын 22 -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, үйлчилгээ нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь “Монгол Улсад коронавируст халдвар хүн амын дунд бүртгэгдсэнтэй холбоотой Гамшгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасны дагуу бүх нийтийн бэлэн байдал зарлаж, онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор шаардлагатай халдваргүйжүүлэх бодисыг (цаашид “бараа” гэх) гэрээ шууд байгуулах аргаар худалдан авах, зайлшгүй шаардлагын улмаас гэрээ байгуулахад өмнө зарлагдаж байсан тендерүүдэд оролцогчдоос санал болгож байсан үнийг үндэслэн, нийлүүлэгч талтай харилцан тохиролцоно.

Захиалагч, нийлүүлэгч тал харилцан тохиролцсоны үндсэн 70,400,000 (далан сая дөрвөн зуун мянган) төгрөгөөр (цаашид “гэрээний гэх) дараах барааг нийлүүлэхээр зөвшөөрөв. Гэрээний үнэ нь нхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

| ааны төрөл | Багцын дугаар | Үйлдвэрлэгч, Улс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /НӨАТ орсон/ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| ьцийн охлорид | 2 | Халдваргүйжүүлэлт ХХК | Сав | 200 | 352,000 | 70,400,000 |
| | | | | | | **70,400,000** |

Захиалагч нь бараа нийлүүлэлтийн 70,400,000 (далан сая дөрвөн зуун мянга) төгрөгийг улсын төсвөөр санхүүжүүлнэ.

Нийлүүлэгч нь дээрх нэр төрлийн барааг .... оны ... дугээр сарын ...-ны өдрөөс .... оны ... дугаар сарын ... -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг[1];
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

4. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

Нийлүүлэгч нь тус гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээнэ.

Гэрээний дагуу холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон шуудангаар харилцана.

Талууд гэрээ байгуулсан даруй Захиалагч 50 хувийн урьдчилгаа төлбөрийг шилжүүлнэ. Нийлүүлэгч шаардлагатай бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлсний дараа нэхэмжлэхийг үндэслэн үлдэгдэл 50 хувийг олгоно.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцын дугаа | Урьдчилгаа /төгрөг/ | Гүйцэтгэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Кальцийн гипохлорид | 2 | 35,200,000 | 35,200,000 |
| Нийт дүн | | | **35,200,000** | **35,200,000** |

[1] ...өр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг.

| | |
|---|---|
| 26 | ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)** | |
| 27 | Монгол хэл |
| **Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)** | |
| 28 | Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө |
| **Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)** | |
| 29 | Эрүүл мэндийн яам, Засгийн Газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2 |
| **Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)** | |
| 30 | Монгол улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх халдваргүйжүүлэх бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн, ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчдад хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

...йн яамны. Нийгмийн эрүүл ...рын дарга Т.Энхзаяа

...йн яамны. Эдийн засаг, санхүүгийн ... дарга Т.Хонгорзул

...йн яамны. Нийгмийн эрүүл мэндийн ...ийн эрүүл байдал, хөдөлмөрийн ...йн асуудал хариуцсан мэргэжилтэн

Э.Гэрэлмаа

...йн яамны. Төрийн захиргааны ... газар. Хуулийн хэлтсийн салбарын ...тогтоомжийн хэрэгжилтийн хяналт ... мэргэжилтэн

...йн яамны. ахлах нягтлан

Э.Эрдэнэцэцэг

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"Халдваргүйжүүлэлт" ХХК-ийн гүйцэтгэх захирал

Ц.Энхжаргал

"Халдваргүйжүүлэлт"ХХК менежер Ц.Наранханд